



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн байршилд баригдах сургууль, цэцэрлэг, авто замын зураг төсөл, барилга угсралт болон худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын асуудлын талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

-Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;

-Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга;

-Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга;

-Нийслэлийн Боловсролын газрын дарга;

-Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга;

-Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дарга;

-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн барилга, орон сууцны бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн.

Нарийн бичгийн дарга:

-Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга.

111020001024

2.Захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, санал, дүгнэлтээ тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Сүхбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian coat of arms and vertical text in Mongolian script. The signature is a cursive, stylized script.

Д.СУМЪЯАБАЗАР